

**ӨМНӨГОВЬ АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 06 сарын 10 өдөр

Дугаар A/33

Даланзадгад сум

┌
Түр журам батлах тухай
└

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2 дахь заалт, 40, 44, 47 дугаар зүйл, Төрийн албаны тухай хуулийн 59 дүгээр зүйл, Хөдөлмөрийн тухай хуулийн 87 дугаар зүйл, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол, Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоол, Зоонозын өвчин судлалын төвийн даргын 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” А/04 дүгээр тушаал, 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн А/12 дугаар тушаалаар батлагдсан дотоод журмыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Зоонозын өвчин судлалын төвийн “Нэмэлт захиалгат үйл ажиллагааны орлогыг зарцуулах түр журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Нэмэлт захиалгат үйл ажиллагааны орлого, зарцуулалтын тайланг байгууллагын шилэн дансанд ил тод нээлттэй мэдээллэж санхүүгийн тайлан, сар бүрийн гүйцэтгэлийн мэдээг гарган тайлагнан ажиллахыг тус төвийн дарга (Б.Гантулга), Ерөнхий нягтлан бодогч (Ш.Түмэнцэцэг) нарт даалгасугай.

3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Удирдлага төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн дарга (Б.Ганшагай)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ЖАВЗАНДУЛАМ

462501198

Эрүүл мэндийн газрын даргын
2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн
А/33 дугаар тушаалын хавсралт

ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ТӨВИЙН НЭМЭЛТ ЗАХИАЛГАТ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫГ ЗАРЦУУЛАХ ТҮР ЖУРАМ

Нэг. Үндэслэл:

1.1.Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, халдварт өвчний дэгдэлт, гамшиг ослын үеийн халдварын голомтыг цомхотгох, эрүүлжүүлэхх, ахуйн хортон шавж, мэрэгч устгал, халдваргүйжүүлэх нэмэлт захиалгат үйл ажиллагааг гүйцэтгэх

Хоёр. Хэрэгжих хугацаа:

2.1.Тус журмыг нэмэлт захиалгат үйл ажиллагааг явуулж буй хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

Гурав. Үйлчилгээний зохион байгуулалт, төлбөр тооцоо:

3.1.ЗӨСТ-ийн даргын 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/04 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан Ахуйн хортон гавьж, мэрэгч устгал, халдваргүйжүүлэлт хийх журмын дагуу

3.2.Иргэд, аж ахуй нэгж байгууллагуудаас дансаар орж байгаа төлбөр, тооцоог ӨМ. Зоонозын өвчин судлалын төвийн нэмэлт санхүүжилтийн данс болох Өм.Зоонозын өвчин судлалын төв н.с- MN390090100110020403 руу төвлөрүүлэх

Дөрөв. Төлбөрийн тооцооны орлогыг зарцуулах:

4.1.Нэн түрүүнд тухайн үеийн төсвийн дутагдлыг нөхөх

4.2.Нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрсөн ахуйн хортон шавж, мэрэгч устгал, халдваргүйжүүлэлтийн орлогыг төвийн даргын шийдвэр, зөвшөөрлөөр байгууллагын үйл ажиллагаанд захиран зарцуулах

4.3.Ахуйн хортон шавж, мэрэгч устгал, халдваргүйжүүлэлт хийхэд шаардагдах хор бодис, дагалдах хэрэгсэл, багаж хэрэгсэл, хувийн хамгаалах хувцас худалдан авах

4.4. Бичиг хэрэг, шаардлагатай эм, урвалж, ариутгал халдваргүйтгэл, бага үнэтэй түргэн элэгдэх зүйл, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, сургалт сурталчилгааны зардал болон тараах материал, хог хаягдлын менежментийн зардал зэрэгт зарцуулах

4.5.Ахуйн хортон шавж, мэрэгч устгал, халдваргүйжүүлэлтэд ажилласан ажилчдын албан томилолт, автомашины шатахуун болон замын зардал, автомашины сэлбэг хэрэгслийн зардалд зарцуулах

4.6.Ахуйн хортон шавж, мэрэгч устгал, халдваргүйжүүлэлтэд ажилласан багийн ажилчид болон удирдан чиглүүлэх, зохион байгуулалтад оролцсон ажилчдад ЗӨСТөвийн даргын 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/04 дүгээр тушаалын дагуу урамшуулал байдлаар тооцож олгох .

4.7.Ахуйн хортон шавж, мэрэгч устгал, халдваргүйжүүлэлтэд ажиллаж байгаа ажилчдад хор тайлах бүтээгдэхүүн, дархлаа дэмжих бэлдмэлээр хангах

4.8.Байгууллагын ажилчдын нийгмийн асуудалд хөнгөлөлт болон дэмжлэг үзүүлэх

Тав. Тайлан, ил тод байдал:

5.1.Нэмэлт захиалгат үйл ажиллагааны орлого, зарцуулалтын тайланг байгууллагын шилэн дансанд ил тод нээлттэй мэдээлнэ.

5.2.Хагас бүтэн жилээр санхүүгийн тайлан, сар бүрийн гүйцэтгэлийн мэдээг гарган тайлагнана.

---oOo---